



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 дугаар сарын 06 өдөр

Дугаар 31

Хэрлэн сум

ХХХИ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 31 дүгээр хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 09:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 92,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Сумдад хөдөлгөөнт эргүүл болон суурин хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх ажлын талаар танилцуулах,

АЗДТГ-ын Цэргийн штаб

2.Ерөнхий боловсролын сургуулиудын 3 дугаар улирлын хичээлийг танхимын сургалтаар үргэлжлүүлэх эсэх талаар хэлэлцэх,

Боловсрол, соёл урлагийн газар

3.Аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штабт Эрүүл мэндийн газраас “Дорнод бүртгэл” системийг нэвтрүүлж 1 сарын хугацаанд ашигласан зардлын тооцоог танилцуулах,

Эрүүл мэндийн газар



ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.АЗДТГ-ын Цэргийн штабын дарга, Онцгой комиссын гишүүн, дэд хурандаа О.Ганзориг-д:

1.1.Сумдад хөдөлгөөнт эргүүл болон суурин хяналтын цэгт байгуулж ажиллахад шаардагдах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

1.2.Эрүүл мэндийн газраас “Дорнод бүртгэл” системийг шинээр зохиож, аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штабт нэвтрүүлэн 1 сарын хугацаанд ашигласан тул “Цахим мэдээллийн сан үүсгэх” ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн гэрээ байгуулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

/  /М.Бадамсүрэн
/  /Д.Баттулга

Хоёр.Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа-д:

2.1.Аймгийн Онцгой комиссын “Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” тогтоолын төсөлд аймгийн Онцгой комиссын гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.2.Аймгийн Онцгой комиссын “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” 24 дүгээр тогтоолд аймгийн Онцгой комиссын гишүүдийн саналыг тусгаж өөрчлөлт оруулж батлуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАГИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА

